



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/534

Булган сум

Газрын хэмжээ өөрчлөх тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар баталсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Д.Ганхуяг (ГЮ80021071)-ийн Булган сум 6 дугаар баг Залуус 10 дугаар гудамж 1005 тоотод байршилтай амины орон сууц зориулалтаар эзэмшиж буй 600 м² газрыг 720 м², Б.Золбаяр (ГЭ87110916)-ын Булган сум 6 дугаар баг Залуус 17 дугаар гудамж 1706 тоотод байршилтай амины орон сууц зориулалтаар эзэмшиж буй 685 м² газрыг 787 м² болгон илүү талбайн дуудлага худалдааны анхны үнийг төлүүлэн кадастрын зургийн дагуу газрын хэмжээг өөрчилсүгэй.

2. Д.Ганхуяг, Б.Золбаяр нартай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Булган сумын Засаг даргын 2007 оны 187 дугаар захирамжийн Д.Ганхуяг, аймгийн Засаг даргын 2015 оны Б/37 дугаар захирамжийн Б.Золбаяр нартай холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ